



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

Албан журмын тайлан болон Сайн дурын гэрээний хүсэлт цуцлах

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
дотоод хэрэгцээнд зориулав.

2024 он


1. БАТАЛГААЖСАН ХҮСЭЛТИЙГ ЦУЦЛАХ

1.1. Албан журмын даатгал

Албан журмыг даатгалын баталгаажсан хүсэлт цуцлах үйлдлийг зөвхөн **ОРЛОГЫН ТАСГИЙН ДАРГА** хийнэ. Хүсэлтийг цуцлахдаа Core системд дараах алхамуудын дагуу ажиллана.


Алхам 1: Байгууллагын тайланг хайх

Даатгалын үйлчилгээ – Хүсэлт - Ажил олгогч хэсгээс Регистрийн дугаар талбараар хайлт хийнэ. Хайлтын үр дүнд тухайн байгууллагын бүх хүсэлтүүд доорх байдлаар харагдана.




Алхам 2: Хүсэлт рүү орох

Цуцлах хүсэлтийн дугаар дээр дарж орсны дараа Орлого шимтгэлийн тасгийн даргад **“Баталгаажсан хүсэлт цуцлах”** товч харагдана.



Алхам 3: Тайланг цуцлах

“Баталгаажсан хүсэлт цуцлах” товч дарахад доорх дэлгэц харагдах ба буцаах шалтгааныг бичиж хадгална.



Хадгалах дарахад систем дараах шалгууруудыг шалгана.

- Хамгийн сүүлийн сараасаа эхэлж цуцлах (Дараагийн саруудад тайлангүй байх)

Анхааруулга ×

400 Та хамгийн сүүлийн баталгаажсан тайлангаас эхэлж цуцлана уу.

- НББ системд авлага хаалтын бичилтгүй байх- Энэ тохиолдолд доорх анхааруулгыг өгөх ба энэ тохиолдолд энэхүү зааврын **2.АВЛАГА ХААЛТЫГ БУЦААХ** хэсгийн зааврын дагуу авлагын хаалтыг буцаана.

Анхааруулга ×

400 НББ систем дээр авлагын хаалтыг буцаана уу.

Цуцлах үйлдэл амжилттай хийгдээний дараа хүсэлт цуцлагдсан төлөвт шилжих ба тухайн тайлангаартай хамааралтай хуваарь, нэхэмжлэх, болон шимтгэлийн ноогдуулалт устгагдсан төлөвт шилжинэ.

1.2. Сайн дурын даатгал

Сайн дурын даатгалын баталгаажсан хүсэлт цуцлах үйлдлийг зөвхөн **ОРЛОГЫН ТАСГИЙН ДАРГА** хийнэ. Хүсэлтийг цуцлахдаа Core системд дараах алхамуудын дагуу ажиллана.

Алхам 1: Сайн дурын даатгалын хүсэлтийг хайх

Даатгалын үйлчилгээ – Хүсэлт - Даатгуулагч хэсгээс Регистрийн дугаар болон бүтээгдэхүүн талбараар хайлт хийнэ. Хайлтын үр дүнд тухайн даатгуулагчийн бүх хүсэлтүүд доорх байдлаар харагдана.

Алхам 1

| # | Хүсэлтийн дугаар | Огноо | Бүтээгдэхүүн | Даатгуулагчийн дугаар | Регистрийн дугаар | Овог | Нэр | Хүсэлт гаргасан салбар | Хариуцсан байцаагч | Сум, дүүрэг | Хүсэлтийн төлөв |
|---|------------------|------------|-----------------------------|-----------------------|-------------------|------|-----|------------------------|--------------------|-------------|-----------------|
| 1 | 20240408-36940 | 2024-04-08 | Сайн дурын даатгал / энгийн | | | | | Чингэлтай дүүрэг | admin | Чингэлтай | Шийдэгдсэн |
| 2 | 20240328-36772 | 2024-03-28 | Сайн дурын даатгал / энгийн | | | | | Хан-Уул дүүрэг | admin | Хан-Уул | Шийдэгдсэн |


Алхам 2: Хүсэлт рүү орох

Цуцлах хүсэлтийн дугаар дээр дарж орсны дараа Орлого шимтгэлийн тасгийн даргад **“Баталгаажсан хүсэлт цуцлах”** товч харагдана.

Алхам 2

Алхам 3: Хүсэлтийг цуцлах

“Баталгаажсан хүсэлт цуцлах” товч дарахад доорх дэлгэц харагдах ба буцаах шалтгааныг бичиж хадгална.



Хадгалах дарахад систем дараах шалгуурыг шалгана.

- НББ системд авлага хаалтын бичилтгүй байх- Энэ тохиолдолд доорх анхааруулгыг өгөх ба энэ тохиолдолд энэхүү зааврын **2. АВЛАГА ХААЛТЫГ БУЦААХ** хэсгийн зааврын дагуу авлагын хаалтыг буцаана.

Анхааруулга×

400 НББ систем дээр авлагын хаалтыг буцаана уу.

Сайн дурын гэрээний хүсэлтийг цуцлахад систем зөвхөн НББ систем дээрээс авлагын хаалт байгаа эсхийг шалгаж байгаа тул гэрээний дүн, гэрээний хугацаа зэрэг бусад шалгууруудыг сайтар нягтална уу.

Цуцлах үйлдэл амжилттай хийгдсэний дараа хүсэлт цуцлагдсан төлөвт шилжих ба тухайн сайн дурын гэрээтэй хамааралтай хуваарь, нэхэмжлэх, болон шимтгэлийн ноогдуулалт устгагдсан төлөвт шилжинэ.


2. АВЛАГА ХААЛТЫГ БУЦААХ

Албан журмыг даатгал болон Сайн дурын даатгалын авлага хаалтыг буцаах үйлдлийг **САНГИЙН НЯГТЛАН БОДОГЧ** хийнэ.

Авлага хаалтыг буцаахдаа НББ дэд системийн Бүтээгдэхүүн - Албан журмын шимтгэл болон Сайн дурын даатгал дэлгэцүүд дээр дараах алхамуудын дагуу ажиллана.

Алхам 1: Буцаах авлагыг хайх

Бүтээгдэхүүн - Албан журмын шимтгэл болон Сайн дурын даатгал дэлгэцүүд дээр Регистрийн дугаар болон Ажил олгогчийн дугаар гэх мэт дурын утгаар шүүж авлагын жагсаалтыг гаргаж ирнэ.



Алхам 2: Авлага хаалт буцаах

Жагсаалт бүрийн хамгийн ард байрлах **“Авлага хаалт буцаах”** товчийг дарснаар тухайн авлагын бүх хаалтууд устаж төлөгдсөн төлбөр нь Урьдчилж орсон орлого дээр нь сэргэж үлдэнэ.



Амжилт хүсье.

